


1. Монгол нутагт 800 мянган жилийн тэртээ хүн амьдарч байсныг нотлох түүхийн дурсгал аль нь вэ? (1оноо)
 - A. Баянхонгор аймгийн Баянлиг сум, Цагаан агуй
 - B. Баянхонгор аймгийн Өлзийт сум, Уран хайрхан
 - C. Дундговь аймгийн Гурван сайхан сум, Ярх уул
 - D. Дорнод аймгийн Булган сум, Норовлин уул
 - E. Ховд аймгийн Алтай сум, Барлагийн гол
2. Уйгурын хаант улс хэдий үед оршин тогтнож байсан бэ? (1оноо)
 - A. МЭӨ209 он
 - B. 98-235 он
 - C. 330-555 он
 - D. 552-745 он
 - E. 745-840 он
3. Хүрлийн үеийн морь хөллөсөн тэрэг дүрсэлсэн хадны зураг хаанаас олдсон бэ? (1оноо)
 - A.Ховд аймгийн Манхан сум Ишгэн толгой
 - B.Ховд аймаг Эрдэнэбүрэн сум Хар хад
 - C.Ховд аймаг Үенч сум Ямаан ус
 - D.Өвөрхангай аймаг Богд сум Тэвш уул
 - E.Улаанбаатар хотын ойр орших Их тэнгэрийн ам
4. Түрэгийн хаант улсыг хэн байгуулсан бэ? (1оноо)
 - A. Билгэ
 - B. Күтүлүг
 - C.Пэйло
 - D. Буман
 - E. Күльтегин
5. Хүннү нарын хэрэглэж байсан амьтны дүрс бүхий ширмэл ширдэг хаанаас олдсон бэ? (1оноо)
 - A. Хараагийн Ноён уул
 - B.Төв аймгийн Алтанбулаг сум
 - C.Өвөрхангай аймгийн Хархорин сум
 - D.ОХУ, Буриадын нутаг, Иволга суурин
 - E.Аль нь ч биш
6. Хүннү гүрний хүн амын үндсэн хэсэг нь ямар угсаатан байсан бэ? (1оноо)
 - A. Түрэг
 - B. Монгол
 - C. Хятад
 - D. Манж-Түнгүс
 - E. Фин-Угор
7. Түрэгийн хаад, ноёд, жанжин нарт зориулан босгосон Орхон-Енисейн бичиг бүхий түүхийн дурсгал аль нь вэ? (1оноо)
 - A.Чингисийн чулууны бичиг
 - B.Монголын нуц товчоо
 - C.Күльтегиний хөшөөний бичээс
 - D.Моюнчурын бичээс
 - E.Аль нь ч биш
8. XI-XII зууны үеийн Гурван Мэргэд аймаг хаагуур нутаглаж байсан бэ? (1оноо)
 - A.Гурван голын сав
 - B.Онон мөрний хөндий
 - C.Онон мөрний хөндий, Сэлэнгийн эхээр
 - D.Орхон голын адаг, Сэлэнгэ мөрний дунд биеэр
 - E.Хангай, Хэнтий нурууны дунд бие, Орхон, Туулын хөндий
9. Монголын нууц товчоонд “Есүхэй худ, би урьд шөнө Цагаан шонхор шувуу нар, сар хоёрыг атган нисч ирээд миний гар дээр суув гэж зүүдлэв.Танай Хиад аймгийн сүлд ирж, зүүдээр дохиолсон ажээ” хэмээн хэн өгүүлсэн бэ? (1оноо)
 - A. Жадараны Жамуха
 - B. Хэрэйдийн Тоорил ван
 - C. Хонгирадын эзэн Дэй сэцэн
 - D.Татарын Тэмүжин үгэ
 - E. Аль нь ч биш
10. Чингис хаан “Эсгий туургатан улсыг энх шударга болгож, есөн хөлт цагаан тугаа мандуулан” хэдэн онд, хаана Их Монгол улсыг байгуулсан бэ? (1оноо)
 - A.1206 он, Гангийн нуур орчим
 - B.1162 он, Ононы Дэлүүн Болдогт
 - C.1189 он, Хар Зүрхний Хөх нуур
 - D.1206 он, Онон мөрний эхэнд
 - E. Аль нь ч биш

11. Хиад -Боржигон овгийн онгон сүлд аль нь вэ? (1оноо)
 А.Цагаан шонхор В. Нар, сар С. Начин шонхор D.Цагаан туг Е. Буга
12. Сүүдрээс өөр нөхөргүй
 Сүүлнээс өөр ташуургүй байхад тайчуудын хөнөөлийг хүлээж, өшөөгөө хэн яаж авах вэ? гэж байхад та нар юунд ийм хэрэг хийв? гэж Өүлэн эх хэнийг, юуны учир зэмлэн сургасан бэ? (1оноо)
 А. Тэмүжинг, дүү Хасарыг буруутган байцаасан гэж
 В. Тэмүжин, Хасар хоёрыг Бэгтэрийг хороолоо хэмээн
 С. Тэмүжинг, Жамухаас хагацан нүүв гэж
 D. Тэмүжинг, Тоорил хаанаас нүүр буруулав гэж
 Е. Аль нь ч биш
13. Жамуха сэцэн ямар овгийн хүн бэ? (1оноо)
 А.Хиад- боржигон В.Жадаран С.Тайчууд D.Жүрхин Е.Баатууд
14. Хулгана жилийн \1240он\ хуран сард бичиж дуусгасан түүхийн зохиол аль нь вэ? (1оноо)
 А.Монголын нууц товчоо В.Чингис хааны чулууны бичээс
 С.Мөнх хааны гэрэлт хөшөөний бичээс D.Юан улсын түүх Е.Аль нь ч биш
15. Нүүдэлчдийн түүхийн хөлгөн судар “Монголын нууц товчоо” зохиогдсон 1240 оныг зууны тоололд шилжүүлсэн зөв илэрхийлэл аль нь вэ? (1оноо)
 А.Х зуун В.ХI зууны II хагас С.ХIII зууны I хагас D.ХII зууны II хагас Е.ХIII зуун
16. Зөв тохируулна уу. (3 оноо)
 1. Их хуралдай а. Хааны амь, бие, орд өргөөг хамгаалах
 2. Хишигтэн б. Улс орны хэмжээний асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргах
 3. Улсын ван в.Улс орны өдөр тутмын хэргийг гүйцэтгэх
 А.1а,2б,3в В.1б,2а,3в С.1б,2в,3а D.1в,2б,3а Е.1в,2а,3б
17. Их Монгол улс байгуулагдсан түүхэн ач холбогдолтой үйл явдалд үл хамаарах зүйл аль нь вэ?
 А. Төрийн бичиг үсэг бий болсноор албан бичгийн хэл бүрэлдэн тогтсон (2оноо)
 В. Монголчуудын оршиж байсан газар нутаг нэгдмэл болж, улсын хил хязгаар бүрдэн тогтоход нөлөөлсөн
 С. Хэл соёл, шашин шүтлэгийн нийтлэг буй болж монгол угсаатан бүрэлдсэн
 D. Төрийн нэгдмэл цааз-Их засаг хуультай болсон
 Е. Алтан улсаас хараат болсон
18. Их Монгол улсын хаадын хаан суусан зөв дарааллыг олно уу. (2оноо)
 А.Чингис, Өгэдэй, Мөнх, Хубилай В.Чингис, Өгэдэй, Хубилай, Мөнх
 С.Чингис, Өгэдэй, Гүюг, Хубилай D.Чингис, Гүюг, Өгэдэй, Мөнх Е.Чингис, Өгэдэй, Гүюг, Мөнх
19. Мөнх хааны төр барьсан хугацаанд болсон үйл явдалд аль нь хамаарах вэ? (2 оноо)
 А. Дүү Хүлэгүг Багдадын халифт улсыг байлдан дагуулуулахаар илгээсэн
 В. Дүү Хубилайг Сүн улсыг эзлүүлэхээр явуулсан
 С. Дүү Аригбөхдөө төрийн хэргийг түр хамааруулсан
 D. Хүн амын тооллогыг дахин хийж албан татварыг цэгцэлсэн

- Е. Дээрх хариулт бүгд зөв
20. Дор дурьдсан өгөгддүүдээс Гүюг хааны төр барьсан хугацааг олно уу? (1 оноо)
 А.1229-1241 он В.1246-1248 он С.1251-1259 он D.1241-1248 он E.1246-1251 он
21. Юан улсын түүхэнд холбогдох өгөгдлийг нэрлэнэ үү. (2 оноо)
 А. Цаасан мөнгө гаргасан В.Пагва ламыг улсын багш өргөмжилсөн
 С. Дөрвөлжин үсэг зохиов D.Хубилай хаан Японыг дайлав E. Бүгд хариулт зөв
22. Доорх зураг юуны тухай өгүүлж байна вэ? (1 оноо)
 А. Соёмбо үсгийн дурсгал
 В. Дөрвөлжин үсгийн пайз
 С. Гүюг хааны тамганы дардас
 D. Ил хааны захидал
 E. Чингисийн чулууны бичиг
- 
23. “Далай лам” хэмээх цол хэрхэн бий болсон бэ? (2оноо)
 А. Түмэн засагт хаан Гарма ламд өгсөн
 В. Халхын ноёд Занабазарт уг цолыг өгсөн
 С. Түмэдийн Алтан хаан Содномжамцад өгсөн
 D. Эрдэнэбаатар хунтайж Зая бандид Намхайжамцад өгсөн
 E. Хубилай хаан Пагва ламд өгсөн
24. Лигдэн хааны ямар бодлогын улмаас Өвөр Монголын олон аймгууд манжийг дагахад хүрсэн бэ? (2оноо)
 А. Манж нарын хүчийг дутуу үнэлж, эвдрэлцсэн
 В. Аливаа асуудалд хатуурхан хүч хэрэглэж, зарим аймгийн дургуйцлийг төрүүлсэн
 С. Монголчууд шарын шашныг шүтэж байхад улааны шашныг илэрхий баримталж байсан
 D. Дээрх хариулт бүгд зөв
 E. Дээрх хариулт бүгд буруу
25. Хэзээ, хаана ямар чуулганаар Монгол, Ойрадын ноёд “Их цааз”-ыг батлан гаргасан бэ? (1 оноо)
 А.1640 он, Тарвагатайн Улаан бураа В.1686 он, Хүрэн бэлчир
 С.1688 он, Ар Элстэй D.1691 он, Долоон нуур
 E.1639 он, Ширээ цагаан нуур
26. Шарын шашин монгол оронд дэлгэрснээр эерэг болон сөрөг нөлөөг үзүүлсэн. Сөрөг нөлөөг дурьдахад илүүц зүйл аль нь вэ? (2 оноо)
 А. Монголчууд хүлцэнгүй болж, эртний дайчин чанараа алдсан
 В. Төрд итгэх үзлийг саармагжуулсан
 С. Түүх, соёлын гайхамшигт дурсгалуудыг бий болгосон
 D. Хүн амын өсөлт зогссон
 E. Илүү зүйл байхгүй
27. Доорх өгөгдлөөс Ойрад Монголчууд Манжид эзлэгдсэн оныг олно уу. (1 оноо)
 А.1755-1758 он В.1691 он С.1636 он D.1634 он E.1631 он

28. Манжийн эрхшээлийн үеийн манжийн хааны албат нарыг гэж нэрлэж байв. (2 оноо)
 A. Сум ард B. Хамжлага ард C. Шавь ард D. Хишигтэн E. Хэвтүүл
29. Манжийг эсэргүүцсэн Лигдэн хааны тэмцлийг дэмжиж байсан хүн хэн бэ? (1 оноо)
 A. Түмдийн Алтан хаан B. Халхын Цогт хунтайж C. Ойрадын Галдан
 D. Халхын Сэцэн хаан E. Аль нь ч биш
30. Аюуш гүүш, Али гали үсэг зохиосон 1587 он хэддүгээр зууны, хэддүгээр хагас вэ? (2 оноо)
 A. XV зууны II хагас B. XVII зууны I хагас C. XVII зууны II хагас
 D. XVI зууны I хагас E. XVI зууны II хагас
31. Манжийн үеийн Сайн ноён хан аймаг нь одоогийн аль аймгуудын нутаг дэвсгэртэй дүйж байна вэ?
 A. Завхан, Говь-Алтай зэрэг аймаг B. Хэнтий, Сүхбаатар зэрэг аймаг (2оноо)
 C. Өвөрхангай, Төв зэрэг аймаг D. Архангай зэрэг аймаг E. Аль нь ч биш
32. 1639 онд Халхын ноёд чуулж, Занабазарыг Халх Монголын шашны тэргүүнээр өргөмжилж, хутагтын “Өргөө”-г байгуулжээ. Энэ үйл явдалтай холбоотой ямар ойг эдүгээ тэмдэглэдэг вэ? (1оноо)
 A. Хархорум хот байгуулагдсны ой B. Улаанбаатар хот байгуулагдсны ой
 C. Ховд хот байгуулагдсны ой D. А ба В хариулт зөв E. Аль нь ч биш
33. Манжийн эрхшээлийн үед гэрээрээ очиж хаадаг албыг гэж нэрлэдэг байв. (2 оноо)
 A. Суман харуул B. Гэр харуул C. Алтны харуул
 D. Дотуур харуул E. Цагдаа харуул
34. Ард Аюушаар удирдуулсан манжийг эсэргүүцсэн монголын ард түмний тэмцэл хаана гарсан бэ?
 A. Түшээт хан аймаг B. Засагт хан аймаг C. Сайн ноён хан аймаг (1оноо)
 D. Сэцэн хан аймаг E. Нийслэл хүрээ
35. 1911.12.29-нд Монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн Богдыг хаан ширээнд залж таван яам байгуулжээ. Шүүх яамны сайдаар хэнийг томилсон бэ? (1оноо)
 A. Да лам Цэрэнчимэд B. Намсрай ван C. Бэйс Гомбосүрэн
 D. Чин ван Ханддорж E. Чагдаржав
36. Доор өгөгдсөн далбааг хэдий үед хэрэглэж байсныг тогтооно уу. (2 оноо)
 A. Манжийн эрхшээлийн үе
 B. Олноо Өргөгдсөн Монгол улсын үе
 C. 1940-1950 оны хооронд
 D. 1921-1924 оны хооронд
 E. Аль нь ч биш



37. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалын гол үр дүнд аль нь **хамаарахгүй** вэ? (2оноо)
 A. Монголын үндэсний тусгаар тогтносон төр улсыг сэргээн тунхагласан
 B. Харийн дарлал, мөлжлөгөөс улс үндэстнээ чөлөөлсөн
 C. Монголчуудын сэргэн мандлын эхлэл болсон

- D. Монгол улсын тусгаар тогтнолыг Дэлхийн олон улс хүлээн зөвшөөрсөн
E. Аль нь ч биш
38. 1915 оны Хиагтын гурван улсын гэрээгээр Монголын тусгаар тогтнолын асуудлыг хэрхэн шийдсэн бэ? (2 оноо)
- A. Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
B. Бүх Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн
C. Монголд Хятадын харьяат автономит эрх олгосон
D. А ба В хариулт зөв
E. В ба С хариулт зөв
39. Доор дурдсан өгөгдлөөс VIII Богд Живзундамба хутагтыг “Төр шашныг хослон барих хэмжээгүй эрхт, хаанд өргөмжлөх ёслол” хэзээ, хаана болсон бэ? (1 оноо)
- A. 1912.12.29-нд Нийслэл Хүрээнд
B. 1911.12.29-нд, Их Хүрээ
C. 1912.12.29-нд Богдын Хүрээнд
D. 1912.12.29-нд, Хүрээ
E. Аль нь ч биш
40. Ардын түр засгийн газрын анхны даргаар хэнийг томилсон бэ? (2 оноо)
- A. Д.Бодоо B. В.Данзан C. Д.Чагдаржав D. Д.Сүхбаатар E. Х.Чойбалсан
41. 1921 оны Монгол, Оросын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай хэлэлцээрт манай улсын тусгаар тогтнолын асуудал хэрхэн тусгагдсан бэ? (2 оноо)
- A. Зөвлөлт Орос улс манай улсыг автономит эрхтэй гэж үзсэн
B. Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн заалт ороогүй
C. Орос, Монгол хоёр тал тус, тусын засгийн газрыг хууль ёсны засгийн газар хэмээн хүлээн зөвшөөрсөн
D. А ба В хариулт зөв
E. В ба С хариулт зөв
42. БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулиар ямар хүмүүсийн улс төрийн эрхийг хассан бэ? (2 оноо)
- A. Бусдыг хөлсөөр ажиллуулагсад
B. Урьдын хаад ноёд, хутагт хувилгаад
C. Хүрээ хийдэд байнга суудаг лам нар
D. Дээрх хариулт бүгд зөв
E. В ба С хариулт зөв
43. Нийслэл Хүрээг хэдэн оноос Улаанбаатар хэмээн нэрлэх болсон бэ? (1 оноо)
- A. 1921 он B. 1922 он C. 1923 он D. 1924 он E. 1925 он
44. Ардын засгийн газрын Цэргийн яамны анхны сайд хэн байсан бэ? (1 оноо)
- A. Пунцагдорж B. Д.Сүхбаатар C. Д.Бодоо D. Н. Магсаржав E. С.Данзан
45. 1924 онд хуралдсан Улсын Анхдугаар Их хурлаас түүхэн ач холбогдолтой ямар шийдвэр гаргасан бэ? (1 оноо)
- A. Богдыг хаан ширээнд залсан
B. Онцгой шийдвэр гаргаагүй
C. Анхдугаар Үндсэн хууль баталж, Бүгд найрамдах байгууллыг тунхагласан
D. А ба В хариулт зөв
E. Аль нь ч биш
46. Монголын түүхэнд “Анхны долоо” хэмээн нэрлэгдэж алдаршсан хүмүүсийн нэг аль вэ? (2оноо)

- A. С.Дамдинбазар В. А.Амар С. Д.Сүхбаатар
D. Ц.Ширнэндамдин Е. Да лам Цэрэнчимэд
47. Монголд 1927-1932 онд “Зүүнтэн” хэмээх нэрийг хэнд хамааруулан нэрлэж байсан бэ? (2оноо)
A. “Гашуудал”, “Нугалаа” “Завхрал” гаргагчид
B. Монголын талаар коминтерний явуулж байсан бодлогыг эсэргүүцэгчид
C. Үндэсний ардчилсан хөгжлийн чиг шугамыг баримтлагчид
D. А ба В хариулт зөв Е. А ба В хариулт буруу
48. ДИУ, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн нь түүхэн ач холбогдолтой үйл явдал болжээ. (2 оноо)
A. 1946.10.01 В. 1942.10.02 С. 1945.10.20 D. 1946.01.05 Е. 1948.12.05
49. 1950-1960-аад оны зааг үед манай оронд тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийн тулд ямар үндсэн бодлого баримтлан, хэрэгжүүлж байсан бэ? (2 оноо)
A. Нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэх
B. Атар газар эзэмших замаар, тариалангийн талбайг нэмэгдүүлэх
C. Тодорхой бодлого үгүй байв
D. Дээрх бүгд зөв
E. Дээрх бүгд буруу
50. “Монголын ардчилсан холбоо” хэзээ, хаана байгуулагдсан бэ? (1оноо)
A.1989.12.10. Улаанбаатар В. 1989.12.12. Ховд С.1990.12.10 Хөвсгөл
D. 1990.12.12. Дархан Е. 1989.12.20 Улаанбаатар
51. 1996 онд Ерөнхий сайдаар ажиллаж байсан улс төрийн зүтгэлтэн хэн бэ? (1оноо)
A. Н.Багабанди В. П.Очирбат С. Н.Энхбаяр D. С.Зориг Е. М.Энхсайхан
52. 1992 оны Үндсэн хуульд зааснаар Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь ямар зарчим дээр хэрэгждэг вэ? (1оноо)
A.Нутгийн өөрөө удирдах ёс В.Сайн дурын удирдлага
C.Төрийн удирдлага D.Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах
E.Аль нь ч биш
53. Дор дурьдсан өгөгдлөөс “Цаг төрийн үймээн” романыг зохиосон зохиогчийг нэрлэнэ үү. (1 оноо)
A. Д.Намдаг В. Л.Түдэв С. Б.Ринчин D. Ч.Лодойдамба Е. О.Цэвэгжав
54. XX зууны Монголын Бүжгийн урлагт үнэтэй хувь нэмэр оруулсан төлөөлөгчид бол юм. (2 оноо)
A.С.Эрдэнэ, Д.Намдаг, Б.Догмид В.Ц.Ядамсүрэн, Г.Одон, Н.Чүлтэм
C.Б.Жамъяндагва, Ю.Оюун, Ц.Сэвжид D.Д.Лувсаншарав, Л.Мөрдорж, С.Гончигсумлаа
E.Б.Сумхүү, Ж.Бунтар, О.Уртнасан
55. Манжийн үеэс одоог хүртэл уламжилж ирсэн засаг захиргааны нэгж аль нь вэ? (1 оноо)
A. Нийслэл В. Дүүрэг С.Сум D. Хороо Е. Хошуу
56. Эдүгээ Монгол улс аливаа улс оронтой харилцахдаа ямар зарчим баримталж байна вэ? (1оноо)
A.Бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хүндэтгэх
B.Бие, биеийн дотоод хэрэгт үл оролцох С.Хүч үл хэрэглэх

D.Маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх

E.Дээрх хариулт бүгд зөв

Хоёрдугаар хэсэг

- 2.1 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)
- | | | |
|-----------------------------------|------------------------------|----------|
| 1. Дорнодын Тамсагбулгийн дурсгал | a. Хуучин чулуун зэвсгийн үе | (5 оноо) |
| 2. Культегиний гэрэлт хөшөө | b. Шинэ чулуун зэвсгийн үе | |
| 3. Ховдын Хойд Цэнхэрийн агуй | c. Хүннүгийн үе | |
| 4. Ноён уулын соёл | d. Түрэгийн үе | |
| 5. Дөрвөлжин булш | e. Хүрэл, Төмрийн үе | |
- 2.2 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)
- | | | |
|---------------------|---------------|---------|
| 1. Төрийн их заргач | a. Шихихутаг | (5оноо) |
| 2. Төрийн бэхи | b. Үсүн өвгөн | |
| 3. Улсын ван | c. Мухулай | |
| 4. Хаан | d. Хөхөчү | |
| 5. Төрийн зайран | e. Чингис | |
- 2.3 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)
- | | | |
|---|--------------------|----------|
| 1. Олноо өргөгдсөн Монгол улс | a. 1911-1915 он | (5 оноо) |
| 2. БНМАУ | b. 1915-1919 он | |
| 3. Монгол улс | c. 1921-1924 он | |
| 4. Автономит Монгол улс | d. 1924-1992 он | |
| 5. Ардын эрхт, хэмжээт цаазат, Монгол улс | e. 1992 оноос хойш | |
- 2.4 Дараах өгөгдлүүдийг зөв тохируулна уу. (1,2,3,4,5 тус бүрт харгалзах утга a,b,c,d,e -ээс сонгоно уу.)
- | | | |
|----------------|--|----------|
| 1.1945.10.20 | a. Монгол хүн сансарт анх нисэв. | (5 оноо) |
| 2. 1946.01.05 | b.Тусгаар тогтнолын асуудлаар бүх нийтийн санал хураалт явагдав. | |
| 3. 1959.12 сар | c. Ардын аж ахуйтныг хоршоолж дуусав. | |
| 4.1961.10.27 | d. ДИУ, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөв. | |
| 5.1981.03.22 | e. БНМАУ, НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болов. | |